



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/1007

Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 26/23 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сонгинохайрхан дүүрэгт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралт ёсоор баталж, уг төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга /Ж.Сандагсүрэн/-д шилжүүлэн, худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, үр дүнг танилцуулж ажиллахыг даалгасугай.

2. Энэ захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах 200.0 /хоёр зуу/ сая төгрөгийг Нийслэлийн 2019 оны төсөвт батлагдсан "Хот тохижилтын бусад зардал"-аас санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Э.Ганхүү/-т, гүйцэтгэлд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар /Б.Мөнхбат/-т, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар /Ш.Үнэнбат/-т тус тус даалгасугай.

3. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавин, гүйцэтгэл, үр дүнг танилцуулж ажиллахыг Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын алба /Т.Гантөмөр/-нд үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ



С.АМАРСАЙХАН

111020904634

Нийслэлийн Засаг даргын 2019 оны  
09 дугаар сарын 30-ны өдрийн  
АМ00/2019 захирамжийн хавсралт

ХОТ ТОХИЖИЛТЫН БУСАД ЗАРДЛААС  
2019 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ ТӨСӨЛ,  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хэрэгжих хугацаа	/сая төг/
			Төсөвт өртөг
1	Ханын материалын комбинатын 58В орон сууцны байрын дээврийн засвар /СХД, 6 дугаар хороо/	2019	100.0
2	Шинээр тоглоомын талбай байгуулах, тохижуулах /СХД, 27 дугаар хороо/	2019	100.0
ДҮН			200.0